

**ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Огноо: 2020 оны 05 дугаар сарын 21

**ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 118 ДУГААР СУРГУУЛИЙН СПОРТ ЗААЛНЫ ШАЛНЫ ЗАСВАРЫН  
АЖЛЫН ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

Төслийн нэр:

**ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 118 ДУГААР СУРГУУЛИЙН СПОРТ  
ЗААЛНЫ ШАЛНЫ ЗАСВАРЫН АЖИЛ**

Төслийн дугаар:

**ХУДХААА/202001060**

**Улаанбаатар хот  
2020 он**

## ҮННИЙ САНАЛ АВАХ УРИЛГА

Огноо: 2020 оны 05 дугаар сарын 21

Тендер шалгаруулалтын нэр: **Хан-Уул дүүргийн 118 дугаар сургуулийн спорт заалны шалны засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах**

Тендер шалгаруулалтын дугаар: ХУДХАА/202001060

**Хан-Уул дүүргийн Худалдан авах ажиллагааны алба** нь эрх бүхий тендерт оролцогчдоос “Хан-Уул дүүргийн 118 дугаар сургуулийн спорт заалны шалны засварын ажил”-ыг гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим тендер шалгаруулалтын Сангийн сайдын 2013 оны 07 дугаар тушаалаар батлагдсан “Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам”-ын ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)) дагуу зохион байгуулж байна.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50.000 (тавин мянган) төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байна

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **30** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Борлуулалтын хэмжээ:
  - Сүүлийн **2** жилд /2018, 2019 он/ гүйцэтгэсэн борлуулалтын орлогын дундаж нь **30 000 000 /гучин сая/** төгрөгөөс багагүй байна.
- Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо:
  - Сүүлийн **2 жил буюу 2018, 2019 он**
- Сүүлийн 2 жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг:
  - 2018, 2019 он сүүлийн 2 жилийн аль нэг жилийн хугацаанд дор хаяж нэг удаа **30 000 000 /гучин сая/** төгрөгөөс багагүй үнийн дүнтэй барилгын засварын ажлын үндсэн гүйцэтгэгчээр орсон байна.
- Тухайн ажилд шаардлагатай тусгай зөвшөөрөлтэй байх. Тийм Үүнд:

**Барилга угсралтын ажил гүйцэтгэх байгууллага нь дараах тусгай зөвшөөрөлтэй байна.**

**Хуучин бол:**

- 2.1.1 Барилгын засвар, засал чимэглэл, орчны тохиижилт.

**Шинэ бол:**

- BA-8.1 Барилга байгууламжийн засвар, засал чимэглэл, интерьер, орчны тохиижилтийн ажил.

Үнийн саналыг **2020 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 09.00 минут**-аас өмнө өмнө цахим системээр илгээх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2020 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 09.30 минут -т** нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх **эрхгүй**.

Монгол Улсын гарал үүсэлтэй бараанд давуу эрхийн зөрүү **тооцно**.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно. Цахим худалдан авах систем ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn))-ээс үнэ төлбөргүй татаж авна уу.

Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3 дугаар хороо, Чингисийн өргөн чөлөө,  
Иргэдэд үйлчлэх төв байр, 9 давхарт 902 тоот, утас: 11-70009011

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч**
  - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
  - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
  - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
  - 2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хоригласан мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгаар баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**
  - 3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:
    - (1) Үнийн санал /маягтын дагуу албан бланк дээр бэлтгэсэн байх/;
    - (2) а. Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;  
б. Үе шатны ажлын хуваарь ;
    - (3) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
    - (4) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
- 4. Тендерийн үнэ**
  - 4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарыт үндэслэнэ.
  - 4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.
  - 4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарыт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.
  - 4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстай бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.
- 5. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
  - 5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байна.

- 6. Алдааг залруулах**
- 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:
- (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэннийг зөв гэж үзнэ;
  - (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
  - (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

**Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

<b>ТОӨЗ-НЫХОЛБОГОХ ЗААЛТ</b>	<b>Шалгуур үзүүлэлт</b>
<b>ТОӨЗ -1.1 (а)</b>	Захиалагч нь: <i>Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар</i>
<b>ТОӨЗ -1.1 (б)</b>	Тендер шалгаруулалтын нэр болон ялгагдах дугаар нь <i>Хан-Уул дүүргийн 118 дугаар сургуулийн спорт заалны шалны засварын ажил, ХУДХАА/202001060</i>
<b>ТОӨЗ -1.1 (в)</b>	Тендерт оролцогч “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай”хуулийн 14.1-д заасан нөхцөл байхгүйг бичгээр мэдээлнэ. <i>/албан бланкан дээр баталгаажуулжс ирүүлнэ/</i>
<b>ТОӨЗ -1.1 (г)</b>	Тендерт гарын үсэг зурах этгээдийн гарын үсгийн баталгааг бичгээр гаргах, түүний итгэмжлэл <i>/МАЯГТ № ТШМ 2-3-ын дагуу албан бланкан дээр баталгаажуулжс ирүүлнэ/</i>
<b>ТОӨЗ -1.1 (д)</b>	Хуулийн этгээдийн бүртгүүлсэн газар, бизнесийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, хаягийг тодорхойлсон Улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар ирүүлнэ. <i>/мөн түнилэлийн гишүүнд хамаарна/</i>
<b>ТОӨЗ -1.1 (е)</b>	Тендерт оролцогч гэрээг хэрэгжүүлэх чадвартайг нотлохын тулд дараах нэмэлт нотлох баримтыг тендерийн хамт ирүүлэх: <ul style="list-style-type: none"> <li>- <i>Шүүхийн төрөлжссөн архивын тодорхойлолт</i></li> <li>- <i>Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн байна. Тендерт оролцогч татварын тодорхойлолтыг ирүүлэх шаардлагагүй ба <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> сайтаас нээлт болсон өдрөөр татварын тодорхойлолтыг захиалагч татан авч үзнэ.</i></li> <li>- <i>Харьяа Эрүүл мэнд, Нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт</i></li> <li>- <i>Хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх тухай харилцагч банкны тодорхойлолт</i></li> </ul> <p><i>Дээрх тодорхойлолтуудыг тендер зарлагдсан өдрөөс хойши авсан байна.</i></p> <p><i>Монгол улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө төлсөн эсэхийг тендер нээсэн өдрөөр тооцно.</i></p>
<b>ТОӨЗ -3.1.2 (а)</b>	<i>1. Ye шатны ажлын хуваарь /гарын үсэг зурж баталгаажуулах/ МАЯГТ № ТШМ 2-1-ын дагуу ирүүлэх</i> <i>2. Тендерт оролцогч нь санал болгосон үнийн дунд багтаан тухайн ажлыг дуусгаж хүлээлгэн өгөх баталгааг бичгээр гаргажс ирүүлнэ. Баталгаа гаргаагүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.</i> <i>3. Тендерийн баримт бичигт заагдсан гэрээний Ерөнхий болон Тусгай нөхцөл, маягт зэргийг зөвшөөрч байгаа талаар мэдэгдэл ирүүлнэ.</i>
<b>ТОӨЗ -3.1.2 (б)</b>	Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь: <i>Ажлын тоо хэмжээний дагуу тооцсон төсөвтэй, эрх бүхий төсөвчнөөр баталгаажуулсан байна/төсвийг ЗТБХБ-ын сайдын 2012 оны 181-р тушаалаар батлагдсан төсөв зохиох дүрэм, БХБ-ын сайдын 2015 оны 185-р тушаалаар батлагдсан барилгын норм ба дүрэм шинэчлэн батлласаны дагуу тооцож Монгол улсад хүчин төгөлдөр хэрэглэгдэж буй төсөв зохиох програмаар хийж гүйцэтгэнэ/. Хөнгөлөлт тооцсон тохиолдолд задаргаа болон үндэслэлийг ирүүлнэ.</i>
<b>ТОӨЗ -3.1.3 (а)</b>	Санхүүгийн тайллан ирүүлэх жилийн тоо: <i>Санхүүгийн тайлланг өөрийн тендертээ хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд цахим системээр дамжуулан Сангийн яамны мэдээллийн сангаас тендерт оролцогчдын сүүлийн 2 жил буюу 2018, 2019 онуудын борлуулалтын орлого, шаардлагатай мэдээллийг давхар шалгана.</i>

	<i>Санхүүгийн тайланг аудитаар баталгаажуулсан байх шаардлагатай эсэх: "шаардлагагүй".</i>																				
<b>ТОӨЗ -3.1.3 (6)</b>	<p>Хийж гүйцэтгэсэн ажлын нийт мөнгөн дүнг жил жилээр харуулсан жагсаалт ирүүлэх шаардлагатай жилийн тоо: <b>2</b></p> <p><i>Сүүлийн 2 жил /2018, 2019 он/</i></p> <table border="1"> <thead> <tr> <th>№</th> <th>Гэрээний нэр</th> <th>Захиалагч байгууллагын нэр, хаяг, холбоо</th> <th>Төсөв төртөг</th> <th>Дууссан эсвэл дуусах хугацаа</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td></td> <td></td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>2</td> <td></td> <td></td> <td></td> <td></td> </tr> <tr> <td></td> <td>Дүн</td> <td></td> <td></td> <td></td> </tr> </tbody> </table>	№	Гэрээний нэр	Захиалагч байгууллагын нэр, хаяг, холбоо	Төсөв төртөг	Дууссан эсвэл дуусах хугацаа	1					2						Дүн			
№	Гэрээний нэр	Захиалагч байгууллагын нэр, хаяг, холбоо	Төсөв төртөг	Дууссан эсвэл дуусах хугацаа																	
1																					
2																					
	Дүн																				
<b>ТОӨЗ -3.1.3 (в)</b>	<p>Борлуулалтын хэмжээ: <i>Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 он</i></p> <p>Борлуулалтын орлогын нийт мөнгөн дүнгийн жилийн дундаж нь: Сүүлийн 2 жилийн хугацаанд гүйцэтгэсэн борлуулалтын орлогын дундаж нь <b>30 000 000 төгрөгөөс багагүй байх.</b></p>																				
<b>ТОӨЗ -3.1.3 (г)</b>	<p>Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын талаарх мэдээлэл ирүүлэх жилийн тоо:</p> <p><i>Сүүлийн 2 жил /2018, 2019 он/-ийн аль нэг жилд ядаж нэг удаа 30 000 000 төгрөгөөс багагүй өртөгтэй барилгын засварын ажил үндсэн гүйцэтгэгчээр гүйцэтгэсэн байх, түүнийг нотлох баримт: Улсын комиссын акт, ажил гүйцэтгэх гэрээ, захиалагч байгууллагын тодорхойлолтын хамт хавсаргана.</i></p> <table border="1"> <thead> <tr> <th>№</th> <th>Гэрээний нэр</th> <th>Захиалагч байгууллагын нэр, хаяг, холбоо</th> <th>Төсөв төртөг</th> <th>Дууссан эсвэл дуусах хугацаа</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td></td> <td></td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>2</td> <td></td> <td></td> <td></td> <td></td> </tr> <tr> <td></td> <td>Дүн</td> <td></td> <td></td> <td></td> </tr> </tbody> </table>	№	Гэрээний нэр	Захиалагч байгууллагын нэр, хаяг, холбоо	Төсөв төртөг	Дууссан эсвэл дуусах хугацаа	1					2						Дүн			
№	Гэрээний нэр	Захиалагч байгууллагын нэр, хаяг, холбоо	Төсөв төртөг	Дууссан эсвэл дуусах хугацаа																	
1																					
2																					
	Дүн																				
<b>ТОӨЗ -3.1.3 (д)</b>	<p>Гэрээг хэрэгжүүлэх удирдах болон инженер, техник, мэргэжилийн голлох боловсон хүчний чадвар, туршлагын талаарх мэдээлэл.</p> <p>Дараах хүснэгтэнд үзүүлсэн удирдах болон инженер техникийн ажилтаныг ажиллуулна.</p> <table border="1"> <thead> <tr> <th>№</th> <th>Албан тушаал</th> <th>Хүчиний тоо</th> <th>Ажилсан жилийн туршлага /мэргэжлээрээ/</th> <th>Мэргэжил</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td>Барилгын инженер</td> <td>1</td> <td>2</td> <td>Барилгын инженер</td> </tr> <tr> <td>2</td> <td>Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан</td> <td>1</td> <td>1</td> <td>Мэргэжил харгалзахгүй</td> </tr> </tbody> </table> <ul style="list-style-type: none"> <li>- <i>Инженер техникийн ажилтнуудын сургууль төгссөн диплом, иргэний үнэмлэхний хуулбар, мэргэжлийн үнэмлэхийн хуулбарыг нотариатаар баталгаажуулсан ирүүлнэ.</i></li> <li>- <i>Барилгын инженер, хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан нь тухайн аж ахуйн нэгжид ажилладаг үндсэн ажилтан байна.</i></li> </ul>	№	Албан тушаал	Хүчиний тоо	Ажилсан жилийн туршлага /мэргэжлээрээ/	Мэргэжил	1	Барилгын инженер	1	2	Барилгын инженер	2	Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан	1	1	Мэргэжил харгалзахгүй					
№	Албан тушаал	Хүчиний тоо	Ажилсан жилийн туршлага /мэргэжлээрээ/	Мэргэжил																	
1	Барилгын инженер	1	2	Барилгын инженер																	
2	Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан	1	1	Мэргэжил харгалзахгүй																	

	<ul style="list-style-type: none"> <li>- <i>Нийгмийн даатгалын дэвтрийн даатгуулагчийн ажил, албан тушаалын өөрчлөлтийн тэмдэглэл, Нийгмийн даатгал төлсөн хэсгийн хуулбарыг нотариатаар баталгаажуулан ирүүлнэ.</i></li> <li>- <i>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан нь ХАБЭА-н сургалтанд хамрагдсаныг нотолж гэрчилгээний /сертификат/ хуулбарыг ирүүлнэ</i></li> <li>- <i>Тендерт оролцогч нь ХУД-т хөрөнгө оруулалтын өөр ажил гүйцэтгэж байгаа болон өөр тендер шалгаруулалтанд оролцож байгаа бол зөвхөн тухайн төсөлт арга хэмжээнд ажиллуулах инженер, техникийн ажилтнуудыг танилцуулах бөгөөд давхцсан тохиолдолд уг тендерээс татгалзах үндэслэл болно.</i></li> </ul>									
ТОӨЗ -3.1.3 (е)	<p>Дараах үндсэн тоног төхөөрөмжийг ажлыг гүйцэтгэх хугацаанд (өөрийн, түрээслэх, хөлслөн авах г.м.) бэлэн байлгах шаардлагатай. Үүнд:</p> <table border="1" style="width: 100%; border-collapse: collapse; text-align: center;"> <thead> <tr> <th>№</th> <th>Тоног төхөөрөмжийн нэр</th> <th>Тоо ширхэг</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td>Ачааны машин /1.5 тонноос дээш/</td> <td>1</td> </tr> <tr> <td>3</td> <td>Үйлчилгээний машин</td> <td>1</td> </tr> </tbody> </table> <ul style="list-style-type: none"> <li>- <i>Хөдөлмөр хамгааллын хувцас, хамгаалах хэрэгсэлтэй байх</i></li> <li>- <i>Машин механизм, тоног төхөөрөмжийн жагсаалтыг МАЯГТ №ТШМ-2 1.4.-т заасны дагуу бөглөж техникийн гэрчилгээний хуулбарыг хавсаргаж ирүүлнэ. Түрээсээр ашиглах бол эзэмшигчтэй нь гэрээ хийж машин механизмын гэрчилгээний хуулбарыг хавсаргана. / хуулбар нь тод гаргацтай байна/</i></li> </ul>	№	Тоног төхөөрөмжийн нэр	Тоо ширхэг	1	Ачааны машин /1.5 тонноос дээш/	1	3	Үйлчилгээний машин	1
№	Тоног төхөөрөмжийн нэр	Тоо ширхэг								
1	Ачааны машин /1.5 тонноос дээш/	1								
3	Үйлчилгээний машин	1								
ТОӨЗ -3.1.3 (ж)	<p>Тендерт оролцогч туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлж болох хувь хэмжээ нь гэрээний үнийн дунгийн <b>10 хувь</b> хүртэл хувь байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Туслан гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг эх хувиар ирүүлнэ.</li> <li>- Гэрээнд туслан гүйцэтгэгчийн гүйцэтгэх ажлын талаар болон төсөвт өртгийг тодорхой тусгасан байна.</li> </ul> <p>Үүнээс дээш хувийг гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэх бол <b>түншлэлийн гэрээ</b> байгуулж тендерийн хамт ирүүлэх ба ТОӨЗ-нд дурдсан бусад шалгуурыг хангасан байх шаардлагатай.</p>									
ТОӨЗ -3.1.3 (з)	<p>Түншлэлийн гишүүд дараах нэмэлт шаардлагыг хангасан байх ёстой. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- <i>Түншлэлийн хувьд чадварын доод шалгур буй эсэхийг тодорхойлохын тулд түншлэлийн гишүүн тус бүрийн үзүүлэлтийг хооронд нь нэмнэ. Гэхдээ гишүүн тус бүр ТОӨЗ 3.1.3/в/ ба /г/-д заасан чадварын доод шалгур үзүүлэлтийг доод тал нь 25 хувийг, төлөөлөх эрх бүхий гишүүн доод тал нь 40 хувийг хангасан байна.</i></li> <li>- <i>Улсын бүртгэлийн гэрчилгээ /нотариатаар баталгаажуулсан байх/</i></li> <li>-<i>Тусгай зөвшөөрөл /нотариатаар баталгаажуулсан байх/</i></li> <li>- <i>“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйлийг хангасан тухай материалыг ирүүлэх.</i></li> </ul>									
ТОӨЗ -3.1.4	<p>Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай /нотариатаар баталгаажуулсан байх/. Үүнд:</p> <p><b>Барилга хот байгуулалтын яамнаас олгодог:</b></p> <p><b>Хуучин бол:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- 2.1.1 Барилгын засвар, засал чимэглэл, орчны тохижилт.</li> </ul> <p><b>Шинэ бол:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- БА-8.1 Барилга байгууламжийн засвар, засал чимэглэл, интерьер, орчны тохижилтийн ажил.</li> </ul>									
ТОӨЗ -2.1 (а)	<p>-“Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар”, Стандартчилал , хэмжил зүйн үндэсний төвийн Зөвлөлийн 2011 оны 02 дугаар тогтооолоор баталсан “Зохион байгуулалт, захирамжлалын баримт бичгийн стандарт” / MNS 5140-1:2011, MNS 5140-2:2011, MNS 5140-3:2011/-ыг мөрдөж тендерийн баримт бичгийг боловсруулна.</p>									

<b>ТОӨЗ 2.1 (б)</b>	<p>Тендерийн эх хувиас гадна ирүүлэх хуулбар хувийн тоо: <b><i>ирүүлэхгүй</i></b></p> <p>Тендерийн материалыг Цахим худалдан авах ажиллагааны систем (<a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>) хаягаар өөрийн ААН-ийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (pdf)-ээр илгээнэ. Цахим систем ашиглан илгээх нийт файлын хэмжээ 100 mb, нэг файлын хэмжээ 15 mb байна. Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу тендерт оролцох хураамж 50'000 /тавин мянган/ тегрэгийг <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>-ээр банкны меркантнийн системийг ашиглан төлнө.</p>
<b>ТОӨЗ 2.1 (в)</b>	<p>Захиалагч тендерүүдийг хүлээн авах хаяг нь: Тендер хүлээн авах этгээд:</p> <p>Тендерийн материалыг Цахим худалдан авах ажиллагааны систем (<a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>) хаягаар өөрийн ААН-ийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (PDF)-ээр илгээнэ. Цахим систем ашиглан илгээх нийт файлын хэмжээ 100 mb, нэг файлын хэмжээ 15 mb байна. Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу тендерт оролцох хураамж 50'000 /тавин мянган/ тегрэгийг <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>-ээр банкны меркантнийн системийг ашиглан төлнө.</p>
<b>ТОӨЗ 2.2</b>	<p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:</p> <p><b>Огноо: 2020 оны 05 дугаар сарын 29-ний өдөр</b></p> <p><b>Цаг: 09 цаг 00 минут</b></p> <p>Тендер хүлээн авах хугацаа нь Цахим худалдан авах ажиллагааны систем (<a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>)-ийн серверийн цагаар тооцогдох тул хугацаа хоцорсон тохиолдолд тендерийн материал хүлээн авах боломжгүй. Тендер хүлээн авах хугацаа дуусахаас өмнө илгээсэн тендерийн материалаа буцаан засварлах, нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй.</p> <p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: <b>Хан-Уул дүүрэг, 3 дугаар хороо, Чингисийн өргөн чөлөө, Иргэдэд үйлчлэх төв байр Худалдан авах ажиллагааны алба</b></p> <p>Давхар болон өрөөний дугаар: <b>9 давхар 902 тоот</b></p> <p><b>Огноо: 2020 оны 05 дугаар сарын 29-ний өдөр</b></p> <p><b>Цаг: 09 цаг 30 минут</b></p>
<b>ТОӨЗ 2.3</b>	<p>Тендерт оролцогч тендерийн материалыд Хувь хүний нууцын тухай болон байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хоригласан мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгаар баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.</p>
<b>ТОӨЗ 6.2</b>	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <b><i>багцгүй</i></b></p>
<b>ТОӨЗ 7.2</b>	<p>Дотоодын давуу эрхийн зөрүү: <b><i>тооцно</i></b></p> <p><b>ТБОНӨХБАУХАТХ-н 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.4-т заасан давуу эрх.</b></p> <p>- Тендерт оролцогч нь давуу эрх эдлэх хүсэлтэй бол албан хүсэлт ирүүлнэ. Албан хүсэлтэд: Уг ажилд ашиглах бараа материалын нэрсийн жагсаалт, тоо ширхэг, нэг бурийн үнэ, нийт үнэ, ажиллах хучийг тусгаж өгнө.</p> <p>- Нотлох баримтад: Тухайн бараа материалын тохирлын гэрчилгээ /нотариатаар баталгаажуулсан байх/, үйлдвэрлэгчтэй байгуулсан гэрээ /эх хувиар/-г ирүүлнэ.</p>

	<p>- Дотоодын давуу эрх <i>тооцуулахаар санал болгож буй иргэд нь тухайн орон нутгийн харьяат иргэд байна</i>. Тэдний иргэний үнэмлэхний хуулбар, ажилд орохыг хүссэн өргөдөл, мэргэжлийн болон диплом, үнэмлэхийн эх хувиас хийсэн хуулбар, оршин суугаа багийн Засаг даргын тодорхойлолт, Хөдөлмөрийн гэрээ эсвэл хөлсөөр ажиллах гэрээ, ажилд томилсон тушаал, хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захирагааны байгууллагатай байгуулсан гэрээ зэрэг бичиг баримтыг шаардсаны дагуу тендерт ируулнэ.</p> <p>- Давуу эрхийг <i>тооцуходоо “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, уйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 10 дугаар зүйл, Сангийн сайдын 2019 оны Давуу эрх тооцох аргачлалыг тус тус баримтлана</i>.</p> <p>Жич: Тендерт оролцогч албан хүсэлт, нотлох баримт ирүүлээгүй бол давуу эрх тооцухгүй.</p>
--	--

**Дөрөв. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

**Холбогдох материалыг хавсралт файлаас үзнэ үү.**

## Тав. АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭ

### a/ ажлын төсөвт өртгийн товчоо

1. Ажлын тоо хэмжээг үнэлэхдээ үнэлэгдэх ажлын тоо хэмжээний жагсаалт болон тендерт оролцогчдод өгөх зааварчилгаа, гэрээний нөхцөлүүд, техникийн тодорхойлолт зэргийг бодит байдалтай холбож нягтлан үзэхийг анхааруулж байна.
2. Гэрээнд тусгайлан заагаагүй нөхцөлд тендерт ирүүлсэн үнийн саналд ажлын тоо хэмжээнд тохиорсон үнэд барилгын ажлыг явуулахад шаардагдах тоног төхөөрөмж, ажиллах хүчний хөлс, материал, түүний элэгдэл засвар, нийгмийн ба эрүүл мэнд, үйлдвэрлэл, ханган нийлүүлэлтийн зардлууд, ашиг бүх төрлийн татвар хураамж, банкны үйлчилгээний шимтгэл, үйлдвэрлэлийн ба ахуйн зориулалттай бүх зардлууд мөн нэмэгдэл дайвар ба захиалагчийн техник хяналтын зардал, гэрээний үүрэгт хамруулах ёстой бусал үүрэг хариуцлагыг тооцож шингэсэн байна.
1. Тухайн ажилд шаардлагатай материалын нийлүүлэлтийн график, захиалгын гэрээний талаарх мэдээллийг ирүүлсэн байх.
2. Ажлын тоо хэмжээг үнэлэхдээ Барилгын төсөв зохиох дүрэм БНБД 81-95-12-ын шинэчлэгдсэн программын дагуу үнэлж, үнэлгээнд техник хяналт, магадлашгүй ажил, НӨАТ, нормчлалын санг тооцож оруулна зэргийг төсөв зохиох зааврийн дагуу нэг бүрчлэн тооцож тусгана.
3. Ажлын тоо хэмжээнд заагдсан ажлыг үнэлэхдээ ажил гүйцэтгэх технологийн дагуу ажил, ажилбаруудаар задалж нэгжийн норм үнэлгээгээр үнэлэхийг анхааруулж байна. Гэхдээ нэгжийн норм үнэлгээ дотроо тусгагдсан ажилбаруудыг дахин давтан үнэлсэн байж болохгүй.
4. Талбайгаас гарсан хог хаягдлыг Хан-Уул дүүргийн зөвшөөрөгдсөн хогийн цэгт тээвэрлэж зайлзуулахаар зардлыг тооцож ирүүлнэ.

### б/ ажлын төсөвт өртгийн товчоо

№/№	Зардлын нэр	Бүгд өртөг /төгрөг/
	Ажиллах хүчний зардал	
	Материал	
	Тээвэр	
	Машин ашиглалт	
	<b>Шууд зардлын дүн:</b>	
	Нэмэгдэл зардал 61%	
	Ашиг	
	<b>Барилга угсралтын ажлын дүн</b>	
	НӨАТ 10%	
	Норм нормативын сан	
	<b>ДҮН</b>	
	Захиалагчийн албаны зардал	
	Зохиогчийн хяналтын зардал	
	Инженер хайгуул, зураг төслийн ажлын дүн	
	<b>ДҮН</b>	
	Магадлашгүй ажлын зардал	
	Бусад нэмэлт зардал	
	<b>НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ</b>	

## АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭ

### ЗАСВАРЫН АЖИЛ

Гүйцэтгэх ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
Спорт заалны шал хийх	м2	345
Шаланд будгаар тэмдэглэгээ хийх	м2	345

**Зургаа. ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ**

**МАЯГТ № ТШМ 2-1**

№	Ажлын нэр	Ажиллах хүч	Ажиллах хоног	Хугацаа /хоног/			
				Гэрээ хийсэн өдрөөс 1 хоног	2 хоног	3 хоног	4 хоног
1							
2							
3							
Нийт							

Тайлбар: Төсөлд тусгагдсан барилга угсралтын ажлыг үндсэн нэр төрлөөр гүйцэтгэх, зүгшрүүлэлт, туршилт тохируулга хийхкомисс ажиллуулан байнгын ашиглалтад хүлээлгэн өгөх зэрэг бүх ажлууд графикт тусгагдана.

Тэмдэг      ГАРЫН ҮСЭГ \_\_\_\_\_  
                   ОВОГ НЭР \_\_\_\_\_  
                   КОМПАНИЙН НЭР \_\_\_\_\_

**ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ**

*[огноо]*

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш 45 хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## ИТГЭМЖЛЭГДСЭН БИЧИГ

Энэхүү тендерийн бичиг баримтад гарын үсэг зурагч \_\_\_\_\_  
Компанийн \_\_\_\_\_ ажилтай \_\_\_\_\_ овогтой \_\_\_\_\_ нь \_\_\_\_\_ компанийн  
нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулах хууль ёсны итгэмжлэгдсэн төлөөлөгч мөн тул  
\_\_\_\_\_ овогтой \_\_\_\_\_ ын дор зурсан гарын үсгийг баталгаажуулж байна.

\_\_\_\_\_ овогтой \_\_\_\_\_ нь \_\_\_\_\_ компанийг төлөөлж \_\_\_\_\_  
компанийн нэр дээр гэрээ, хэлцэл байгуулах, ажил эхэлж дуусгах, гүйцэтгэл гаргах,  
гологдлыг барагдуулах, албан бичиг баримт явуулах зэрэг сонгон шалгаруулалтад  
холбогдолтой бүх материалд гарын үсэг зурах эрхтэй болно.

Энэхүү итгэмжлэх бичгийг гэрчилж 2017 оны \_\_ дугаар сарын \_\_ ны өдөр гарын үсэг  
зурвас.

Тэмдэг

Байгууллагын итгэмжлэгдсэн төлөөлөгчийн  
Овог, нэр \_\_\_\_\_  
Гарын үсэг \_\_\_\_\_  
Албан тушаал \_\_\_\_\_

Баталгаажуулагчийн  
Овог, нэр \_\_\_\_\_  
Гарын үсэг \_\_\_\_\_  
Албан тушаал \_\_\_\_\_

# ГЭРЭЭНИЙ МАЯГТ

## ЗАХИАЛАГЧ

## ГҮЙЦЭТГЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

(Албан тушаал)

*[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.*

Дугаар № *[Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]*

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ сарын \_\_\_\_\_-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

**1.** Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж сууринуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

**2.** Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

**3.** Гэрээний нийт дүн: \_\_\_\_\_ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/

Улсын төсвөөс: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг.

**4.** Гүйцэтгэгч нь \_\_\_\_\_ байршилтай \_\_\_\_\_ хүчин чадал бүхий \_\_\_\_\_ ам.метр талбай / \_\_\_\_\_ шоо метр эзлэхүүн/-тай, \_\_\_\_\_ суурь, \_\_\_\_\_ хана, \_\_\_\_\_ хучилттай, \_\_\_\_\_ давхар \_\_\_\_\_ барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж сууринуулах/-ын ажлыг \_\_\_\_\_ инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, \_\_\_\_\_ туслах барилга /бусад ажил/-ын хамт \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_\_-ны өдөр эхэлж, \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_\_-ны өдөр ашиглалтад оруулна.

**5.** Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1.** Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2.** Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 5.3.** Үнийн санал
- 5.4.** Гэрээний тусгай нөхцөл;
- 5.5.** Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6.** Техникийн тодорхойлолт;
- 5.7.** Зураг;
- 5.8.** Гүйцэтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь :

- 5.9.** Санхүүжилтийн хуваарь;  
**5.10.** Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

- 6.** Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.
- 7.** Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзольд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
- 8.** Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
- 9.** Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Umac/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

**ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Umac/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

## Найм. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |   |   |
|---|---|
| <b>1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх</b>                         | 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ.  |
| <b>2. Төслийн менежерийн шийдвэр</b>                        | 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ.   |
| <b>3. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх</b> | 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана.  |
| <b>4. Аюулгүй байдал</b>                                    | 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.<br>4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ. |
| <b>5. Зааварчилгаа</b>                                      | 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй  |
| <b>6. Маргааныг шийдвэрлэх</b>                              | 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлтэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.  |

## Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ

- |                                     |   |
|-------------------------------------|---|
| <b>7. Ажлын хөтөлбөр</b>            | 7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.<br>7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана. |
| <b>8. Зөрчил, гологдол илрүүлэх</b> | 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй.  |
| <b>9. Зөрчил, гологдол арилгах</b>  | 9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.<br>9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.   |

- 10. Зөрчил, гологдол арилгахгүй байх**
- 10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэл заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.

## **В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ**

- 11. Үе шатны ажлын хуваарь**
- 11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарь тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.
- 11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.
- 12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх**
- 12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарь нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.
- 13. Алданги**
- 13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги төлне. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

## **Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ**

- 14. Ажил дуусгах**
- 14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлзуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.
- 15. Хүлээж авах**
- 15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.
- 16. Эцсийн тооцоо**
- 16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ.  
Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно.  
Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ.  
Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.
- 17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлага**
- 17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.

- 17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг сүутгана.
- 18. Гэрээг цуцлах**
- 18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.
- 18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:
- (а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;
  - (б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;
  - (в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;
  - (г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;
  - (д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.
- 18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.
- 19. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр**
- 19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.
- 19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.
- 20. Гүйцэтгэлээс чөлөөлөх**
- 20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсоон. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

## Ес. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

<b>ГЕН 2.1</b>	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: <i>Хан-Уул дүүргийн 118 дугаар сургуулийн спорт заалны шалны засварын ажил, ХУДХАА/202001060</i>
<b>ГЕН 2.1</b>	Ажлын талбай нь: <i>Хан-Уул дүүрэгт</i> байршина.
<b>ГЕН 3.1</b>	Төслийн менежер нь <i>Б.Энхболд /Засаг даргын Тамгын газрын дарга/</i>
<b>ГЕН 3.1</b>	Ажил эхлэх өдөр <i>Гэрээ байгуулсан өдрөөс</i> Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр <i>Гэрээ байгууллагдсанаас хойши 15 хоног</i> <i>Хэрэв гүйцэтгэгч нь тус ажлыг хугацаанд нь дуусгаж чадаагүй тохиолдолд гэрээнд заагдсаны дагуу алданги ноогдуулна.</i>
<b>ГЕН 7.1</b>	Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш <b>6</b> хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
<b>ГЕН 9.1</b>	Чанарын баталгаа нь гэрээний үнийн дүнгийн <b>5 хувь</b> байна.
<b>ГЕН 13.1</b>	Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн <b>0,05 хувь</b> байна.  Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн <b>10 хувь</b> байна.
	Шилэн дансны тухай хуулийн дагуу <a href="https://www.shilendans.gov.mn/">https://www.shilendans.gov.mn/</a> -сайтад бүртгэлтэй байх, “Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 10 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий ажил, үйлчилгээ гүйцэтгэсэн талаарх улирлын мэдээлэл (Улирал бүр)” хэсэгт хүлээн авсан санхүүжилтэй мэдээлсэн байх